



БУГАТ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Аудитор: Б.Үүрийнтуяа
Утас: 70423073
Цахим хаяг: Elbegeeuuree@yahoo.com

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.bayan-ulgii.gov.mn

2018 оны 3 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээ тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 14-нээс 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018 оны 03-р сарын 09-ны өдрийн №65-р албан бичгээр 3 дугаар сарын 26-нд буюу 20 хоногоор хугацаа хоцроож ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 3 дугаар сарын 26-наас 4 дүгээр сарын 04-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 4 дүгээр сарын 05-нд Бугат сумын Засаг даргад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын багц хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Хариуцлага , хяналтыг сайжруулж, ил тод үр ашигтай байдлыг эрхэмлэх ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно”, 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д заасны дагуу Бугат сумын Засаг дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. 2017 оны төсвийг орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан Бугат сумын төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 10-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус сумын төсвийн байгууллагууд санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг мөрдөж ажилласан ба

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан тэмдэглэл тодруулга, бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Пластик” ашиглаагүй Е тайлангийн нэгтгэлээр гаргаж ирүүлсэн, төсөвт байгууллагууд “Аколоус” програм хангамж ашиглажээ.

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Аймгийн ТЭЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

6.1. Орлого, татаас санхүүжилтийн талаар:

6.1.1 Улсын төсвийн санхүүжилт

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 1480,1 сая төгрөгийн санхүүжилт, 3,2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

6.1.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагууд аймгийн төсвөөс 256,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 72,2 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр 46,3 сая төгрөг хүлээн авчээ.

6.1.3 Үндсэн үйл ажиллагааны орлого

Бугат сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагаанаас 0,7 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 0.4 сая төгрөгийн орлого оруулж, өөрийн орлогын төлөвлөгөөг 42,9 хувиар тасалдуулсан байна.

6.1.4 Орон нутгийн татварын орлого

Бугат сумын ИТХ-аас сумын 2017 оны Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 45,3 сая төгрөгөөр баталжээ. Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 16,7 хувийг ХАОАТатвараас, 77,6 хувийг бусад татвараас, 5,6 хувийг өмчийн татварын орлогоос оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Нийт орлогын дүн	45270.0	72260.0	26990.1	159.62%
Татварын орлого	45270.0	68367.0	23097.0	151.02%
ХАОАТатвар	7590.0	6526.9	1063.1	85.99%
Өмчийн татвар	2546.0	2140.0	-406.0	84.05%
Бусад татвар	35134.0	59700.1	24566.1	169.92%
Татварын бус орлого	0.0	3893.1	3893.1	
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО		0,00		

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 72,3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 27,0 сая төгрөгөөр буюу 59,6 хувиар давуулан биелүүлжээ. Нийт орлогын 9,0 хувийг ХАОАТатвар, 82,6 хувийг бусад татвараас, 3,0 хувийг өмчийн татвараас, 5,4 хувийг татварын бус орлогоос бүрдүүлжээ. Татварын бус орлогын төлөвлөгөө өгөгдөөгүй ба хүү торгууль, банкны хадгаламжийн хүүгийн орлогоос 3,9 сая төгрөгийн орлого оруулсан ба энэ нь орлогын 5,4 хувийг эзэлж байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд бусад татвар 24,6 сая төгрөгөөр буюу 69,9 хувиар давж, ХАОАТатвар 1,1 сая төгрөгөөр буюу 14,0 хувиар, өмчийн татвар 0,4 сая төгрөгөөр буюу 16,0 хувиар, үл хөдлөх хөрөнгө борлуулсны албан татвар 100 хувиар тус тус тасарчээ. Төлөвлөгөө өгөгдөөгүй татварын бус орлогоос 3,9 сая төгрөг оруулж орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелэгдэхэд гол нөлөө үзүүлжээ.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 15,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 72,3 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 30,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. Өмнөх оны үлдэгдлээс 15,5 сая төгрөгийг сумын ИТХ-ын 2017 оны 3-р сарын 17-ны өдрийн хуралдааны 13 тоот

тогтоолоор ЗДТГазрын урсгал зардалд, нөөц хөрөнгөнд зарцуулжээ. Орон нутгийн орлогын 910 тоот дансны оны эцсийн үлдэгдэлд Баяннуур сумаас таашаарч орсон 3,4 сая төгрөгийг үлдэгдэлд харуулсаныг, залруулж өглөгөөр харуулав.

Сумын төрийн сан дахь цалин хөлсний татварын орлогын 901 тоот дансаар нийтдээ 92,4 сая төгрөгийн орлогыг оруулж, газрын төлбөрөөс 1,4 сая төгрөгийн нийтдээ 93,8 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Сумын төсөвт байгууллагуудаас төлсөн цалин хөлсний татварын орлогыг тухай бүр аймгийн ЦХТОрлогын дансанд төвлөрүүлж ажилласан байна.

6.1.5 Бусад орлого

Тайланд онд Орон нутгийн хөгжлийн санд 35,9 сая төгрөгийн санхүүжилт авч, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 18,9 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн санд 3,7 сая төгрөгийн орлого оруулсан байна.

6.2. Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

6.2.1 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2017 оны урсгал зардалд нийтдээ 1909,9 сая төгрөгийн төсөв батлагдсаны 1480,0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 301,2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 35,9 сая төгрөгийг ОНХСангаас, 77,2 сая төгрөгийг үйл ажиллагааны орлого, урьд оны үлдэгдлээс 15,5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгажээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 1480,1 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 301,2 сая төгрөгийн, ОНХСангаас 35,9 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үйл ажиллагааны орлогоос 19,4 сая төгрөгийг үйл ажиллагааны орлого, 15,5 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлж бүгд дүнгээр 1852,0 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан төсвөөс 57,9 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1909.9	1852.0	96.9%	57.9
1.1	Урсгал зардал	1817.2	1817.2	0.0%	0.00
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0

2	Зардлыг сахуужуулэх эх үүсвэр	2727.8	2727.8	0,0%	0,0
2.1	Тусгай зориулалтын шилжүүлэгээс	1480.1	1480.1	0,0%	0.0
2.2	Орон нутгийн төсвөөс	301.2	301.2	0,0%	0,0
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	35.9	35.9	0,0%	0,0
2.4	Үндсэн үйл ажиллагааны орлого, урьд оны үлдэгдэл	92.7	34.8	37.5%	57.9

Сумын төсвийн гүйцэтгэл Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс төлөвлөсөн орлого бүрдээгүйтэй холбоотой дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал:

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Сумын ИТХурал	43.3	43.3	-	100.0
2	Сумын ЗДТГазар	290.8	290.8	-	100.0
3	Ахлах сургууль	837.6	837.6	-	100.0
5	ЭМТөв	287.5	287.5	-	100.0
8	Хүүхдийн цэцэрлэг	300.9	300.9	-	100.0
9	Соёлын төв	54.8	54.5	0.30	99.5
10	ОНХСан	18.4	18.9	- 0.5	102.7
11	СХСан	76.5	18.4	58.1	24.1
	Нийт дүн	1,909.8	1,851.9	57.9	97.0

Сумын төсөвт байгууллагууд батлагдсан төсвөө бүрэн авч, төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

/сая төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,909.90	1,852.00	57.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,187.20	1,187.20	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэ	137.90	137.90	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84.90	84.70	0.20
2104	Хангамж, бараа материалын зардал	33.30	33.70	(0.40)
2105	Нормативт зардал	133.10	133.00	0.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6.60	6.60	-
2107	Томилуулт, зочны зардал	3.10	3.00	0.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55.20	55.70	(0.50)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88.70	30.20	58.50
213	Бусад урсгал шилжүүлэг	179.90	180.00	(0.10)

6.2.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 49,5 төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулсны дотор урсгал зардалд 49,5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үүнд: ЗДТГазарт аймгийн Онцгой байдлын хэлтэсээс 4,0 сая төгрөгийн, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 0,6 сая төгрөгийн, ХХААГазраас бруцеллёзын зардалд 11,6 сая төгрөгийн, ИТХуралд 1,0 сая төгрөгийн, БДСургуульд орон нутгаас 1,2 сая төгрөгийн, Соёлын төвд БСУШУЯамнаас 1,0 сая төгрөгийн, сумын орон нутгийн орлогоос 30,1 сая төгрөгийн нийтдээ 49,5 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан бүрэн зарцуулж, оны 0,08 сая төгрөгийн орон нутгийн дансанд төвлүүлсэн байна.

6.2.3 Сангуудын зарцуулалт

Бугат сумын ОНХСан нь оны эхэнд 0,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 35,9 сая төгрөгийн санхүүжилт авч, 18,5 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд, 17,4 сая төгрөгийг мал эмнэлгийн үйлчилгээний арга хэмжээний зардалд зарцуулж, оны эцэст үлдэгдэлгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд үлдэгдэлгүй, тайлант онд эргэн төлөлтөөс 18,9 сая төгрөгийн орлогыг оруулж, тайлант онд 17,9 сая төгрөгийн зээл олгож, 0,4 сая төгрөгийн бусад зардалд зарцуулж, оны эцэст 0,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. СХСан нь жилийн эцэст 203,0 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

Эргэлтийн эмийн сангийн харилцах данс оны эхэнд 1,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 3,7 сая төгрөгийн орлого оруулж, 4,9 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 0,013 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

6.3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаарх тайлбар, тодруулга

6.3.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	17.20	31.01	13.81
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	17.20	31.01	13.81
3121	Төгрөг	17.20	31.01	13.81
31211	Төрийн сангийн харилцах	16.00	30.94	14.94
31213	Арилжааны банк дахь харилцах	1.20	0.07	(1.13)

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 31,0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 0,07 сая төгрөг нь арилжааны банкин дахь, 30.94 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна. Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдлийн 30,4 сая төгрөг нь Орон нутгийн ерөнхий орлогын, 0,5 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 0,013 сая төгрөг нь ЭЭСангийн, 0,06 сая төгрөг нь ИТХ-ын арилжааны банкин дахь дансны үлдэгдэл байна.

Арилжаны банкинд байгаа 0,07 сая төгрөг нь Эргэлийн эмийн сан, ИТХ-ын дансны үлдэгдэл байна.

6.3.2 Авлагын бүртгэл, тайлагнал

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
33	АВЛАГА	222.4	214.3	8.1
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	8.40	11.10	(2.70)
33300	Татаас, санхүүжилтийн авлага	9.60		9.60
335	Бусад авлага	0.50	0.30	0.20
3351	Байгууллагаас авах авлага		0.30	(0.30)
3352	Хувь хүмүүсээс авах авлага	0.50		0.5
336	Зээлийн авлага	203.90	202.90	1.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	203.90	202.90	1.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	203.90	202.90	1.00

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 8,1 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Төсөвт байгууллагуудын авлага нь 9,3 сая төгрөг нь ЗДТГазрын, 1,2 сая төгрөг нь БДСургуулийн, 0,6 сая төгрөг нь ХЦэцэрлэг, 0,3 сая төгрөг сумын ОНХСангийн бүгд 11,4 сая төгрөгийн, 203.0 сая төгрөгийн СХСангийн авлагатай гарсан байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоо нийлж, зээлдэгч нэг бүрээр гарын үсэг зуруулж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

6.3.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
35	БАРАА МАТЕРИАЛ	32.40	40.80	(8.40)
351	Түүхий эд материал	5.90	6.10	(0.20)
354	Хангамжийн материал	25.80	33.90	(8.10)
35600	Мал амьтад	0.70	0.80	(0.10)

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 8,4 сая төгрөгөөр буурсан байна. Бараа материалын бүтцийг авч үзвэл 15,0 хувь нь түүхий эд материал, 83,1 хувь нь хангамжийн материал, 1,7 хувь мал амьтад байна. Тайлант онд нийтдээ 7,6 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч орлого авсан байна.

6.3.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,457.90	2,406.50	(51.40)
391	Газар			-
392	Биет хөрөнгө	2,457.60	2,406.30	(51.30)
393	Биет бус хөрөнгө	0.30	0.20	(0.10)

Үндсэн хөрөнгө оны эхнээс 51,4 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 0,7 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 87,5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. Төсөвт байгууллагууд нийтдээ 87,5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас Бүрэн дунд сургууль БСУШУЯмнаас 87,5 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтаар хүлээн авсан байна. Тайлант онд 16,0 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 139,6 сая төгрөгийн элэгдэл тооцож, данснаас хассан үндсэн хөрөнгийн 16,0 сая төгрөгний элэгдэлийг данснаас хасалт хийсэн байна.

6.3.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11.80	15.90	4.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11.80	15.90	4.10
413	Өглөг	11.80	15.90	4.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		12.50	12.50
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		3.40	3.40
4136	Бусад өглөг	11.80	-	(11.80)
41361	Байгууллагад төлөх өглөг	11.80		(11.80)

Оны эхэнд 11,8 сая төгрөгийн өглөгтэй байснаас, оны эцэст 15,9 сая төгрөг гарч, өглөг 4,1 сая төгрөгөөр өссөн байна. Оны эцсийн өглөг нь сумын төсөвт байгууллагуудад сумын ЗДТГазар 6,4 сая төгрөгийн, БДСургууль 3,7 сая төгрөгийн, ЭМТөв 1,1 сая төгрөгийн, Цэцэрлэг 1,0 сая төгрөгийн, СТөв 0,3 сая төгрөгийн, Төрийн сан 3,4 сая төгрөгийн бүгд 15,9 сая төгрөгийн тус тус өглөгтэй гарчээ. Төсөвт байгууллагуудын ихэнх өглөг ЗГазраас олгосон Сахилга үр дүнгийн урамшуулал цалингийн байгууллагаас төлөх 11 хувийн НДШимтгэлийн өглөг, ТСангийн 3,4 сая төгрөгийн өглөг тус тус эзэлж байна.

6.3.6 Цэвэр хөрөнгө/өмчийн талаар

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн нийт дүн 2676,9 сая төгрөг буюу ЗГОКапитал 1374,6 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 724,2 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 578,1 сая төгрөг байна. Тайлант онд -41,3 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн 578,1 сая төгрөг болж буурсан байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Бугат сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу shilendans.gov.mn вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагдсан төсвийн мэдээллийг оруулсан байна.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2017 оны 1-9 дүгээр сарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар хуулийн 6-р зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.3.5, 6.3.8, 6.3.9 дэх заалтуудыг зөрчсөн зөрчил илэрч албан шаардлага өгөгдөж, биелэлтийг 2017.12.26-ны өдрийн №274 тоотор ирүүлсэн байна.

Найм. Аудитын дүнгийн талаар

8.1. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 30 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

8.2. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний Орон нутгийн орлогын бүртгэл, тайлагнал, санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэл, төсөвт байгууллага, сангуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг нэгтгэх, тулган баталгаажуулах зэргээр ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

8.3. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитаар санхүүгийн тайланд нөлөөлэх материаллаг дараах алдаа зөрчлүүд зөрчил илэрлээ.Үүнд:

1. ТТЗ-ийн СНТайланг санхүүгийн “Пластик” программаар нэгтгэж, гаргаж ирүүлээгүй, Е-тайлангаарх СНТ-г нэгтгэлийг устгах бичилт хийгдээгүй дүнгээр алдаатай гаргаж ирүүлсэн. СНТ-ийн тэмдэглэл тодруулгыг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэж ирүүлээгүй. Сумын ОНХСан, СХСан, Төрийн сангийн санхүүгийн тайланг гаргаж ирүүлээгүй, Е-тайланд зөрүүтэй тайлагнасан.Төсвийн шууд захирагчийн аудитын хугацаанд СХСангийн тайлан, санхүүгийн баримтуудыг ирүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: *Зөрчил тооцож, зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөө.*

2. “Монгол Сафари” ХХК-ниас төлсөн 30.1 сая төгрөгийн агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогыг Сумын Агнуурын нөөцийн төлбөрийн 100020400946 тоот дансанд оруулж, орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн боловч төсвийн орлогын гүйцэтгэлд оруулж тайлагнаагүй, 19.0 сая төгрөгийн агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогыг сумын ХААН банкинд 5196016849 тоот данс нээж, төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлээгүй, шууд зарцуулж төсвийн орлогын

гүйцэтгэлд оруулж тайлагнаагүй, нийтдээ 49.1 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлд оруулаагүй, гүйцэтгэлийг дутуу тайлагнасан.

Аудитын явцад шаардлагатай мэдээлэл, баримт материал болох "Монгол Сафари" ХХК-тай байгуулсан ан агнуурын гэрээ, арилжааны банкинд нээсэн дансны хуулга, баримтуудыг авч ирж үзүүлээгүй, төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан. Үүнтэй холбоотой Сумын Агнуурын нөөцийн төлбөрийн 100020400946 тоот дансанд "Монгол Сафари" ХХК-наас 2017 оны 11 дүгээр 13-нд орсон 34.9 сая төгрөгийг 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр "илүү шилжүүлснийг буцаасан" гэх шалтгаанаар шилжүүлсэнийг тодруулах, орлогын бодит гүйцэтгэлийг тооцоолох боломжгүй байна.

Дээрхи зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 23-р зүйлийн 23.8, 23.8.4, 35.4, 41.2.1, дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Зөрчил тооцож, зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.*

3. Агнуурын нөөцийн төлбөрийн 100020400946 тоот дансанд "Монгол Сафари" ХХК-наас орсон 30.1 сая төгрөгийг ОНЕРөнхий орлогын 100020400910 тоот данснаас сумын ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансанд оруулж, ИТХурлын тогтоол, шийдвэр гаргуулахгүйгээр, Засаг даргын захирамжаар шууд зарцуулж ЗДТГ-ын төсвийн зарлагын гүйцэтгэл, Сумын төсвийн нэгдсэн зарлагын гүйцэтгэлд оруулж тайлагнаагүй, зарлагын гүйцэтгэлийг дутуу тайлагнаж эрх хэмжээгээ хэтрүүлсэн байна. Үүнд гэрээт ажилчдын цалин, НДШ, ХХОАТатварт 8.2 сая төгрөг, "Айбек" хоршоонд урсгал засварт 3.2 сая төгрөг, "Жана төбө" ХХК шатахууны зардалд 3.7 сая төгрөг, "АСУСАЙН" ХХК-д ангийн отог 14.4 сая төгрөг, 2 ажилтанд цалингийн урьдчилгаанд 0.6 сая төгрөг нийтдээ 30.1 сая төгрөг зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.2.2, 6.2.5, 6.3.4, 6.4.1, 6.6.1, 6.6.2, 6.6.4, 16.5.5, 41.2.2, 41.2.3, 42.7 дахь заалтуудыг зөрчсөн байна.

4. "Монгол Сафари" ХХК-наас сумын ХААН банкин дахь 5196016849 тоот дансанд орсон 19.0 сая төгрөгийг Засаг даргын баталсан өр барагдуулах жагсаалтыг үндэслэн ЗДТГазрын дарга Ө.Харилбай, санхүүгийн албаны дарга А.Жамбал нар 1, 2 дугаар гарын үсэг зурж төсвийн хууль тогтоомж зөрчиж шууд зарцуулсан байна.

Үүнд: сумын Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/133 тоот захирамжаар сумын ЗДТГазрын НДШ-ийн өглөгт 3.0 сая төгрөг, Тамгын газрын автомашины засварт 1.0 сая төгрөгийн, иргэн Саулегүлд банзны үнэ, Есимбай тусламжинд 0.2 сая төгрөг, бэлэг дурсгалд 0.09 сая төгрөг, АКЕСА дэлгүүрээс 3 ширхэг нотбүк, 1 ширээний компьютер, 1 ширхэг принтер 3.2 сая төгрөг, НИК ХХК-нд шатахууны үнэ 1.0 сая төгрөг, ОБГазрын нүүлгэн шилжүүлэхэд гарсан зардалд "Ахтай" ХХК-нд 0.5 сая төгрөг, Соёлын төв, ЗДТГазрын гаднах засвар, байгууллагуудын урсгал засвар, сантехникийн засварт 5.7 сая төгрөг, ЭМТөвийн хатуу зөөлөн эдлэлийн үнэд 2.0 сая төгрөг, байгаль хамгаалагч нарын нормын хувцас үнэд 0.6 сая төгрөг, сумын Санхүүгийн албаны даргын 9,10-р сарын цалинд 1.0 сая төгрөг, 2 хүнд 0.7 сая төгрөгийн бүгд 19.0 сая төгрөгийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулжээ.

Дээрхи төсөвт байгууллагуудад худалдан авсан 5.8 сая төгрөгийн техник хэрэгсэл, бусад хөрөнгө нь тухайн төсөвт байгууллагуудад орлого авагдаагүй, данс бүртгэлд тусгагдаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, 41.2.3, 42.7, НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг зөрчсөн.

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар Сумын ЗДТГазарт авсан 3,2 сая төгрөгийн техник хэрэгсэл, Эрүүл мэндийн төвд авсан 2,0 сая төгрөгийн хатуу зөөлөн эдлэлийг тухайн байгууллагуудад орлого авахуулж, данс бүртгэл, санхүүгийн тайланд тусгуулах.

ЗДТГазрын барилгын гадна талын засвар, Соёлын төвийн барилгын засвар, автомашинд хийгдсэн урсгал засваруудын ажлын даалгавар, төсөв, гүйцэтгэл, гэрээ, хүлээн авсан акт зэрэг анхан шатны баримт материалыг бүрдүүлж, баримтжуулах тус албан шаардлага өгч, Сумын ЗДТГазар, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн сантехник, гагнуурын хөлсөнд 2,0 сая төгрөг, Сумын ЗДТГазрын шатахууны үнэд НИК ХХКомпанид 1,0 сая төгрөг, иргэн Саулегүл, Есимбай нарт 0,2 сая төгрөг бүгд 1,2 сая төгрөг, Санхүүгийн албаны дарга А.Жамбалын 9, 10-р сарын цалинд 1,0 сая төгрөг, Б.Хажымурат, Ө.Ахбота нарт 0,7 сая төгрөг нийтдээ 4,9 сая төгрөгийг холбогдох тооцоо, цалингийн хүснэгт, тушаал шийдвэргүйгээр, батлагдсан орон тооноос гадуур баримтгүйгээр зарцуулсныг 4,9 сая төгрөгийн акт тогтоов.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 4,8 сая төгрөгийн албан шаардлага өгч, зориулалт бус зарцуулсан 4,9 сая төгрөгийн акт тогтоов.

5. Сумын ЗДТГазрын 2017 оны төсөвт орон тооны хязгаарыг 24.5 хүнээр баталсан боловч гүйцэтгэлээр 28.5 орон тоо ажилуулж, орон тоог 4-ээр илүү ажиллуулсан байна. 2017 онд шинээр 1 дотоод ажил хариуцсан ТҮ-1-1 шатлалаар, 1 аж ахуй үйчилгээний болон гэрээт ажилчдыг хариуцсан эрхлэгчийг ТҮ-5-2 шатлалаар, 2 галч гэрээтээр цалингийн доод хэмжээ батлагдсан орон тооноос илүү ажиллуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын Засаг даргад зөрчил арилгуулах албан шаардлага өгөө.

6. Сум хөгжүүлэх сан нь жилийн эцсийн байдлаар 203,0 сая төгрөгийн зээлийн авлагатай бөгөөд санхүүгийн тайланд зээлийн хүүгийн авлагыг тусад нь харуулаагүй, авлагын үлдэгдэлд тайлант хугацааны хүүг тооцож, орлогоор бүртгэж аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлд тэмдэглэж цаашид анхаарч ажиллахыг зөвлөв.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг бус дараах зөрчил илэрсэн.Үүнд:

1. Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 8.9.3-т "сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны төсвийн хагас жилийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж дээд шатны төсвийн

ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны дотор дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчиж 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангаа 3 дугаар сарын 26-ны өдөр буюу 20 хоногоор хугацаа хоцроож ирүүлсэн.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох албан тушалтнуудад хариуцлага тооцуулах санал өгөхөөр болов.

8.4. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогоос орсон 30,1 сая төгрөгийг төсвийн орлогын гүйцэтгэлд, арилжааны банк дахь дансаар оруулж зарцуулсан 19,0 сая төгрөгийг төсвийн орлого, зарлагад залруулагдаагүй болно.

8.5. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал үгүй байна.

8.6. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой зарим асуудлыг гүйцээж шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар нарийвчлан шалгах шаардлагатай.

8.7. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

8.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

8.9. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Бугат сумын ИТХурал, Соёлын төвийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж, Бүрэн дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд бие даасан дүгнэлт гаргалаа.

Сумын Засаг даргын тамгын газар, ОНХСан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд оруулав.

Аудитын үр дүнг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /мян. төг/	Аудиторын санал дүгнэлт бүгд	Үүнээс			
			Зөрчилгүй санал дүгнэлт	Хязгаарлалттай санал дүгнэлт	Сөрөг санал дүгнэлт	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Сумын ЗДТГазар	63741.1	-				
Бүрэн дунд сургууль	78956.9	1	1			
ЭМТөв	-	1	1			
Хүүхдийн цэцэрлэг	1266.0-	1	1			
ТТЗ-ийн СНТайлан	463834.1	1			1	
Дүн	й607798.1	4	3		1	

8.10. Сөрөг санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН
Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК
Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА
Огноо:2018.04.04